

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАНД

ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Грант нь “Шинжлэх ухаан, технологийн тухай” Монгол улсын хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу онолын суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэх хэлбэр юм.

Тайлбар: “Грант” гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилан тавьсан болзлынхоо дагуу тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулахаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй, эргэн төлүүлэхгүйгээр олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг хэлнэ.

2. Грантаар олгох санхүүжилтын хэмжээг БСШУЯ, ШУА-иас жил бүр тогтоож байна.
3. Нийгмийн бодит хэрэглээ болгох боломжтой онолын суурь судалгааны ажлын завсрын болон эцсийн үр дүнд зайлшгүй шаардлагатай нэмэлт судалгаа тооцоо, үндэслэл, боловсруулалт хийлгэх зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грантыг нэг жилийн хугацаатай олгож байна.

Тайлбар: Нийгмийн ухааны салбарт төрийн бодлого боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл болохуйц судалгааны үр дүн, олон нийтийн оюуны хэрэгцээг хангахуйц ном бүтээлийг бодит хэрэглээ гэж үзнэ.

4. Грантаар санхүүжүүлэх ажлын оролцон гүйцэтгэгч нь магситрант болон оюутан байж болно.
5. Грантын зохих хувийг судалгааны ажилд зайлшгүй шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис болон бусад материал, ном зохиол худалдан авахад зарцуулж болох бөгөөд гадаад томилолтын болон суралцах зардалд зориулж болохгүй.
6. Грантын 40 хүртэлх хувийг гүйцэтгэгчийн цалинд зарцуулж болно.

**Хоёр. Грантаар санхүүжүүлэх судалгааны үр дүнг сонгох,
баталгаажуулах**

1. Судалгааны ажлын үр дүнг грантаар санхүүжүүлэх саналыг эрдэм шинжилгээний байгууллага гаргана.
2. Тухайн эрдэм шинжилгээний байгууллага уг асуудлыг эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн гаргасан шийдвэрээ холбогдох бичиг баримтын хамт салбарын бага чуулганд ирүүлнэ.

Жич: Дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- Эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын протокол, тогтоол
 - Судалгааны ажлын үр дүнгийн тодорхойлолт (1-2 нүүр)
 - Грантаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зардлын нарийвчилсан тооцоо
 - Грантын мөнгөөр багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд материал, ном зохиол гадаадаас худалдан авах бол авах улс, орон, байгууллагын нэр, хаяг, үнэ, тээврийн зардал, гаалийн татвар зэргийг тусгасан хүснэгт
 - Уг ажлыг үйлдвэр, практикт нэвтрүүлснээр гарах үр дүн, өгөөж
 - Грантаар санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэх эрдэм шинжилгээний ажилтны ажил байдлын тодорхойлолт, тухайн сэдэвтэй холбогдох бүтээлийн жагсаалт
 - Үр дүнг хүлээн авах байгууллагын санал
3. Ирсэн саналыг салбарын Бага чуулганы хурлаар хэлэлцэн зөвлөмжөө ШУА-ийн Тэргүүлэгчдийн хуралд оруулна.
 4. Грант олгох ажлын талаар Тэргүүлэгчдийн хурлаас тогтоол гаргана.
 5. Грантаар санхүүжүүлэх ажлыг ШУА, тухайн эрдэм шинжилгээний байгууллага, гүйцэтгэх эрдэм шинжилгээний ажилтны гурван талын гэрээний дагуу хэрэгжүүлнэ. Гэрээг ШУА-ийн Ерөнхийлөгч баталгаажуулна.
 6. Үр дүнгийн тайланг бага чуулган болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын шийдвэрийн хамт Шинжлэх ухааны Академийн тэргүүлэгчийн газарт ирүүлж байна.

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗАР

